



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 413

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр 1, 2, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 168 дуаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн яамны хөрөнгөд бүртгэлтэй 147,300,000.00 (нэг зуун дөчин долоон сая гурван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 24,550,000.00 (хорин дөрвөн сая таван зуун тавин мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Агаараас эрэн хайх 111 дүгээр ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Агаараас эрэн хайх 111 дүгээр ангийн захирагч хурандаа Т.Мөнхдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003055

2022.09.29 22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
 2022 оны 09 дүгээр сарын 21 өдрийн  
 111 дугаар тогтоолын хавсралт

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АГААРААС ЭРЭН ХАЙХ**

**111 ДҮГЭЭР АНГИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

д/д	Автомашинны нэр, марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
		Сери	Дугаар				
1	Суудлын автомашин Ланд крузер-200	УНУ	56-03	2013	147,300,000.00	24,550,000.00	122,750,000.00
<b>Нийт дүн</b>							
					(нэг зуун дөчин долоон сая гурван зуун мянга)	(хорин дөрвөн сая таван зуун тавин мянга)	(нэг зуун хорин хоёр сая долоон зуун тавин мянга)